

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 03

Багануур дүүрэг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээний зорилго нь “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ хийн удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд чиглэл авахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 6.7 дахь хэсгүүдийг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 29 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилтэд удирдлага болгож буй журмын дагуу хяналт-шинжилгээ хийхэд:

- Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш – 26 арга хэмжээ
- Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувьд хүрээгүй – 3 арга хэмжээ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаа дуусаж байгаа бодлогын баримт бичгийн ангилалд тооцож, журмын 6.4 дахь хэсэгт заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш 93 хувьтай байгаа учир үр дүнтэй гэж дүгнэлээ.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 29 арга хэмжээ тусгагдаж, дундаж хэрэгжилт 93 хувьтай байна. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувьд хүрээгүй – 3 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн зөвлөмж:


1.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилга худалдан авах – 0%

2.Паркийн тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичгийг боловсруулж, тусгай зөвшөөрөл авах ажлыг шийдвэрлүүлэх – 50%

3.Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим, үйлдвэрлэлийн чиглэлүүдийг барьж ажиллан олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж гэрээ, санамж бичиг байгуулах, шинэ инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд санал санаачилга гарган ажиллаж паркад шинээр 2 нэгж элсүүлэх – 50%

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын дагуу паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авахад бүрдүүлэх чухал бодлогын баримт бичгүүдийн бүрдэл хангадаагүй байгаа нь үндсэн үйл ажиллагаа болох нэгж үйлдвэрүүдийг элсүүлэх, бүтээн байгуулалтын ажил эхлүүлэхэд хууль эрх зүйн хүрээнд нийцэхгүй байгаа тул 2025 онд санхүүжилт шийдвэрлэгдсэн Хөгжлийн төлөвлөгөө, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг 2026

онд гүйцэтгэгч байгууллагаас гэрээний хугацаанд хүлээн авах, 2025 онд нэгжээр элсэхээр хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан 4 аж ахуй нэгж байгууллагын Техник эдийн засгийн үндэслэлийг холбогдох ямаар баталгаажуулан паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэн яаралтай авах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.



ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.Тан-Ундрах